



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 04 сарын 13 өдөр

Дугаар 22

Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3, 6 дугаар зүйлийн 6.2.1, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын есдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 17,000,000 /арван долоон сая/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй 49-21ДУА улсын дугаартай SUBARO маркийн автомашиныг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газрын дарга (Р.Отгонбаатар)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Сум, байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг актлах, акталснаас гарсан сэлбэгийг эргэлтийн хөрөнгөд бүртгэх, худалдан борлуулах;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3 Акталсан тээврийн хэрэгслийг авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хасуулах арга хэмжээг авч ажиллах;


2.4. Энэ тогтоолын биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн
... тогтоолын хавсралт



Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газрын актлах тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалт ад орсон огноо	Тээврийн хэрэгслийн			Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	
			Серий	Дугаар			Арлын дугаар	Моторын дугаар	Моторын эзлэхүүн /см3/					
1	Суудал	SUBARO	ДУ	49-21	2006	2012-01-21		4500	150	157096	17000000	17000000	0	
Хөрөнгийн дүн												17,000,000	/Арван долоон сая төгрөг/	



**ДУНДГОВЬ АЙМГИЙН ОРОН
НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР**

48090 Мандалговь, Сайнцагаан сум

Утас: 70593232, 70593399

e-mail: umch@dundgovi.gov.mn

2022. 04. 15

№

81

танай

-ны №

-т

**БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Р.ОТГОНБААТАР ТАНАА**

Танай ирүүлсэн хүсэлтийн дагуу Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай аймгийн ИТХ-ын 2022 оны 22 дугаар тогтоол гарсан тул тогтоолын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлнэ үү.

Хавсралт... хуудас

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ ~~Ж.БАНТУЛГА~~

